



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2019 оны 01 сарын 08 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.3, 6.4.4, 6.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад тусгагдсан Гаалийн ерөнхий газрын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг шинээр барих бэлтгэл хангах зайлшгүй шаардлагыг харгалзан Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 798,752,926.54 (долоон зуун ерэн найман сая долоон зуун тавин хоёр мянга есөн зуун хорин зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө) төгрөгийн балансын үнэ, 328,115,993.53 (гурван зуун хорин найман сая нэг зуун арван таван мянга есөн зуун ерэн гурван төгрөг тавин гурван мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий үл хөдлөх хөрөнгө болох хавсралтад заасан барилгыг буулгаж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогт, Гаалийн ерөнхий газрын дарга Б.Асралт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг буулгаж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Үл хөдлөх хөрөнгөнд хамаарах газар (чөлөөлөгдөх талбай)-ыг албан зориулалтаас өөр хэлбэрээр ашиглахгүй байх;

2.4. Үл хөдлөх хөрөнгийг буулгаж, ашиглаж болох эд зүйлийг ялган тоолж данс бүртгэлдээ тусган, худалдан борлуулах;

2.5. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАВАА

Төрийн ёмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 01 дүгээр сарын 28.-ний өдрийн
дугаар тогтоолын хавсралт

Гаалийн ерөнхий газрын үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй актагж, данснаас хасах барилга, байгууламж

Д/Д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон он	Байршил	Балансын үнэ (төгрөг)	Хууримтлагдсан элтэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	Лабораторийн барилга	2004	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81- 1, Гаалийн ерөнхий газрын хашаанд	361,370,631.06	73,501,120.75	287,869,510.31
2	Спорт заал, гараашийн барилга	2004	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81- 1, Гаалийн ерөнхий газрын хашаанд	262,308,289.00	215,440,947.57	46,867,341.43
3	Гараашийн барилга /6 машины дотор хүүчин/	1995	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81- 1, Гаалийн ерөнхий газрын хашаанд	47,161,475.00	22,068,950.25	25,092,524.75
4	Ажилчдын цайны газар /УОБ-ны агуулах, архив, узель/	1995	Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Их тойруу 81- 1, Гаалийн ерөнхий газрын хашаанд	127,912,531.48	17,104,974.96	110,807,556.52
				798,752,926.54 (доллоон зуун ерэн найман сая долзоон зуун тавин хоёр мянга есэн зуун хорин зургаан төгрөг тавин дөрвөн мөнгө)	328,115,993.53 (гурван зуун хорин найман сая нэг зуун арван таван мянга есэн зуун ерэн гурван төгрөг тавин дөрвөн мөнгө)	470,636,933.01 (дөрвөн зуун далан сая зургаан зуун гучин зургаан мянга есэн зуун гучин гурван төгрөг нэг мөнгө)
				Нийт дун		